



**БСШУСЯ-НЫ ХАРЬА
БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН**

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Гэрээний дугаар 81201513

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ” ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2016

АГУУЛГА

Оршил Товчилсон нэр

НЭГ. БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТХБ-ЫН ҮЗЭЛ САНААГ ТУСГАН БОЛОВСРУУЛАХ

- 1.1 Бүрэн дунд боловсролын нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санааг тусган боловсруулах /хавсралт 1- CD/
- 1.2 Бүрэн дунд боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санааг тусган боловсруулах /хавсралт 1-CD/
- 1.3 Бүрэн дунд боловсролын амьдрах чадварт суралцах сургалтын зөвлөмжид ТХБ-ын үзэл санааг тусган боловсруулах /хавсралт 1-CD/
- 1.4 Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн хяналт /эксперт/ хийлгэх /хавсралт 2/
- 1.5 Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудын сургалтын менежер, багш нараар хэлэлцүүлэх, засан сайжруулах /хавсралт 3/

ХОЁР. БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

- 2.1 ТХБ-ын үзэл санаа, ойлголтын талаар Боловсролын хүрээлэнгийн ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах /хавсралт 4/
- 2.2 ТХБ-ын чиглэлээр ном, зөвлөмж, гарын авлага судлах /хавсралт 5/
- 2.3 ТХБ-ын талаарх судалгааны үр дүнг боловсруулах программууд /SPSS, BILOG MG/-д суралцах гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах /хавсралт 6/
- 2.4 ШУА-ийн жинхэнэ гишүүд, боловсролын ШУ-ны доктор /Sc.D/ -уудтай уулзалт зохион байгуулж, ТХБ-ын үзэл санаа шинжлэх ухааны салбаруудад хэрхэн туссан талаар судлан, эрдэмтдийн судалгааны арга зүйд суралцах
- 2.5 Сургалтын хөтөлбөр, сурах бичигт ТХБ-ын үзэл санаа туссан эсэх судалгааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах дотоодын зөвлөх ажиллуулах
- 2.6 Сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа туссан эсэхийг илрүүлэх шалгуур боловсруулах, судалгааг хэрхэн хийх талаар боловсролын бодлогын болон хөтөлбөрийн судалгааны секторын ЭША-уудад сургалт зохион байгуулах/хавсралт 7/
- 2.7 Сурах бичигт ТХБ-ын үзэл санаа туссан эсэхийг илрүүлэх шалгуур боловсруулах, судалгааг хэрхэн хийх талаар сурах бичгийн судалгааны секторын ЭША-уудад сургалт зохион байгуулах /хавсралт 8/

ХАВСРАЛТ

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙГ ЛАБОРАТОРИ СУРГУУЛИУДЫН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР, БАГШ НАРААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТАЙЛАН

ТАНИЛЦУУЛГА

БШУ-ны сайдын 2013 оны 5-р сарын 8-ны өдрийн А/155-р тушаалаар баталсан Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд “Боловсролын чанарын шинэчлэл хийхдээ дэлхийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны онцлог, бусад хүчин зүйлийн нөлөөг тооцож, тогтвортой хөгжүүлэх хөгжлийн бодлого, үзэл баримтлалаа шинээр тодорхойлох шаардлага тулгарч байна” гэж заасны дагуу 2013-2014 оны хичээлийн жилд бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, 2014-2015 оны хичээлийн жилд суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан. БСШУ-ны сайдын 2016 оны 10-р сарын 22-ны А/424-р тушаалаар батлагдсан 171 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, УБ хотын лаборатори 17 сургуулийн 10 дугаар ангид тус хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж байна.

2016-2017 оны хичээлийн жилээс бүрэн дунд боловсролд мөрдөх сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг шалгуурын дагуу шинжлэн үнэлэх, мэргэжлийн багш, сургалтын менежерүүдээр хэлэлцүүлж санал авах, ЕБС-ийн 10 дугаар ангийн хичээл, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх судалгаат хичээл зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийг эцэслэн боловсруулах зэрэг нь үндэслэл болно.

ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, хэрэгжүүлэх хөтөлбөр болон хичээл, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа туссан байдлыг илрүүлэх

Зорилт

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах 3 зорилтыг тавьж ажиллав.

1. Хөтөлбөр боловсруулагчид бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжих сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын үзэл санаа туссан эсэхэд шинжилгээ хийх
2. Лаборатори сургуулийн мэргэжлийн багш нар, сургалтын менежерүүдэд 10 дугаар ангийн сургалтын цөм хөтөлбөрийг хэлэлцүүлж, сайжруулах санал авах, хичээл төлөвлөлтийн дагуу заавал судлах хичээлийн агуулга, арга зүйд ТХБ-ын үзэл санааг тусгах судалгаат хичээл зохион байгуулах
3. Бүрэн дунд боловсролд хэрэгжүүлэх хөтөлбөр болон тавигдах шаардлагын дагуу сургуулийн хөтөлбөр боловсруулах, хичээл үйл ажиллагааг зохион байгуулах

СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН АРГА, АРГАЧЛАЛ

Бүрэн дунд боловсролд хэрэгжүүлэхээр боловсруулагдаж буй сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг илрүүлэх шалгуур үзүүлэлтийг 2014 онд БСШУЯ, МУБИС-аас хийсэн “Олон түвшинт суурь судалгаа”, БСШУ-ы сайдын 2016 оны 11 дүгээр сарын 13-ны А/458 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага” болон олон улсын баримт бичигт үндэслэн боловсруулж хэрэглэсэн болно.

Сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг илрүүлэх шалгуурыг

- Хамааралтай
- Хэмжигдэхүйц
- Нөлөөлөхүйц байхаар боловсруулсан.

Хамааралтай гэдэг нь: ТХБ-ын агуулга, арга зүйг илрүүлэх боломжтой байх

Хэмжигдэхүйц гэдэг нь: сургалтын хөтөлбөр, хичээл, үйл ажиллагаа болон сургууль, орон нутагт үргэлжилсэн хугацаанд хэмжих боломжтой байх

Нөлөөлөхүйц гэдэг нь: Хөтөлбөр боловсруулагчид болон бодлого хэрэгжүүлэгч, шийдвэр гаргах түвшнийхэнд танилцуулах, тэдний шийдвэрт нөлөөлөх боломжтой байхуйцаар боловсруулсан юм.

Сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүний сонголт туссан байдлыг илрүүлэхэд анхаарч дараах хэрэгслүүдийг боловсруулж хэрэглэсэн. Үүнд:

- ТХБ-ын үндсэн агуулга болох мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлага, хэтийн төлөв болон асуудал, элементүүдийн хоорондын холбоо хамааралд илүү төвлөрч боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу хөтөлбөр боловсруулагчид хөтөлбөрийн төсөлд шинжилгээ хийх хуудас
- ТХБ-ын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ сургалтын цөм хөтөлбөрт туссан байдлын талаар багш нараас авах санал асуулгын хуудас
- Хичээл төлөвлөлтийн загвар
- Хичээл үйл ажиллагаанд ажиглалт, хэлэлцүүлэг хийх хуудас
- Даалгаварт шинжилгээ хийх хуудас
- Орон нутаг, сургуулийн тулгамдсан асуудлыг тодорхойлох хуудас
- Сургуулийн хөтөлбөр боловсруулах загвар
- Сургуулийн хөтөлбөрт шинжилгээ хийх хуудас

СУДАЛГААНЫ АГУУЛГА

Судалгааны агуулга нь дараах асуудлыг хамарсан.

1. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд шинжилгээ хийсэн үр дүн

- 1.1. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал судлах цөм хөтөлбөрийн төсөл, суралцахуйн удирдамжид ТХБ-ын агуулга туссан байдалд хөтөлбөр боловсруулагчдын хийсэн шинжилгээний үр дүн
- 1.2. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал судлах цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүний сонголт туссан байдалд мэргэжлийн багш нарын өгсөн дүгнэлт, санал
- 1.3. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал сонгон судлах хичээлийн хэрэгжүүлэх хөтөлбөр, сургуулийн хөтөлбөр боловсруулахад тавигдах шаардлагад ТХБ-ын үзэл санааг тусгах боломжийг хэлэлцүүлсэн байдал

2. Ахлах ангийн хичээл, үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусгах судалгаат хичээл зохион байгуулсан байдал

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд шинжилгээ хийсэн үр дүн

1.1. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал судлах цөм хөтөлбөрийн төсөл, суралцахуйн удирдамжид ТХБ-ын агуулга туссан байдалд хөтөлбөр боловсруулагчдын хийсэн шинжилгээний үр дүн

ТХБ-ын танин мэдэхүйн агуулга заавал судлах сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд туссан байдал

Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын нийгэм соёлын асуудлыг 29, байгаль орчны асуудлыг 20, эдийн засгийн асуудлыг 14 шалгуур үзүүлэлтээр шинжилж үзлээ.

А. Нийгэм соёлын асуудал

Хөтөлбөр боловсруулагчид бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал судлах 10 судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын нийгэм соёлын асуудал хэрхэн туссан байдалд шинжилгээ хийсэн үр дүнг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан нийгэм соёлын асуудал

Судлагдахуун	Товч дурдсан агуулга "1"	Хувь	Нэлээд дурдсан "2"	Хувь	Бүлгийн талаас тусгасан "3"	Хувь	Хөтөлбөр тус бүрт тусгагдсан элементийн нийт тоо	Хувь
Математик	8	14	1	2	0		9	5.3
Хими	1	2	3	5	3	5	7	4
Биологи	10	18	3	5	7	13	20	12
Монгол хэл	6	11	14	25	31	55	51	30.3
Физик	0		0		0		0	
Газарзүй	0		5	9	0		5	3
Англи хэл	2	4	0		34	61	36	21.6
Орос хэл	2	4	5	9	28	50	35	21
Нийгэм судлал	19	34	6	11	14	25	39	23.3
Түүх	8	14	17	30	10	18	35	20.6
Нийт	56	23,6	54	22,8	127	53,6	237	33.3

10 дугаар ангид хэрэгжүүлэх 10 судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийн төслийн 23,6%-д ТХБ-ын нийгэм соёлын асуудал товч дурдагдсан байгаагаас харахад ихэнх сургалтын цөм хөтөлбөрт тодорхой хэмжээгээр тусгагдсан гэж дүгнэж болохоор байна. Харин нийт хөтөлбөрийн 53,6%-д ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын нийгэм соёлын асуудал бүлгийн талаас илүү түлхүү тусгагдсан байна. Бүлгийн талаас түлхүү тусгагдсан судлагдахуунд нийгэм, хүмүүнлэгийн ухаан (түүх, нийгмийн ухаан, орос хэл, монгол хэл, англи хэл)- ы сургалтын цөм хөтөлбөр багтаж байна.



Нийгэм соёлын асуудлын хүний эрх (Н4), дэлхийн тэгш байдал ба шударга ёс (Н5), эрүүл мэнд (Н12), харилцаа (Н13), хэл соёл (Н14), соёлын ялгаатай байдал ба соёл хоорондын ойлголцол (Н16), соёлын ялгаатай байдал ба соёл хоорондын ойлголцол (Н16), аюул осол, эрсдлээс сэргийлэх (Н18) зэрэг элементүүд 2-5 сургалтын цөм хөтөлбөрт бүлгийн талаас түлхүү тусгагдсан байна. Бусад элементүүд нь судлагдахууны онцлогтойгоор тодорхой хэмжээнд тусгагдсан байна.


Б.Байгаль орчны асуудал

ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын байгаль орчны асуудлаас сургалтын хөтөлбөрт нэн тэргүүнд тусгах шаардлагатай 20 элементийн жагсаалт гаргаж сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд туссан байдлыг шинжилж үзлээ.

Хүснэгт 2. Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан байгаль орчны асуудал

Судлагдахуун	Төвч дурдсан агуулга "1"	Хувь	Нэлээд дурдсан "2"	Хувь	Бүлгийн талаас тусгасан "3"	Хувь	Хөтөлбөрт тус бүрт тусгагдсан элементийн нийт тоо	Хувь
Математик	9	17,6	0		0		9	5.8
Хими	1	2,0	4	8,3	9	16,4	14	9
Биологи	0		7	14,6	13	23,6	20	12.7
Монгол хэл	0		20	41,7	0		20	14
Физик	1	2,0	1	2,1	0		2	1.4
Газарзүй	0		0		20	36,4	20	12.1
Англи хэл	19	37,3	0		0		19	12.4
Орос хэл	13	25,5	1	2,1	0		14	9.2
Нийгэм судлал	0		9	18,8	11	20,0	20	13
Түүх	8	15,7	6	12,5	2	3,6	16	10.5
Нийт	51	33,1	48	31,2	55	35,7	154	33.3

Хүснэгтээс харахад 10 дугаар ангийн 10 судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд байгаль орчны асуудлын элементүүд жигд тусгагдсан байна. Газар зүй, биологи, хими болон нийгэм судлалын сургалтын цөм хөтөлбөрүүдэд бүлгийн талаас илүү тусгасан нь судлагдахууны онцлогоос хамаарсан бөгөөд нийгмийн ухаан, хүмүүнлэгийн хичээлүүдэд төвч дурдсан байгаа нь аль ч судлагдахууны хөтөлбөрт байгаль орчны асуудлын элементүүд жигд тусгагдсан байна гэдгийг харуулж байна.



Танин мэдэхүйн агуулгын байгаль орчны асуудлуудаас ус (Б5), агаар (Б6), хөрс (Б7), хөдөө аж ахуй, бэлчээр ашиглалт (Б9), бохирдол (Б16) зэрэг элементүүд 4 сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд бүлгийн талаас илүү тусгагдсан байхад байгалийн гамшиг (Б4), эрчим хүч (Б8), уламжлалт мэдлэг (Б19) зэрэг элементүүд 4-5 сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд нэлээд дурдагдсан байна.

В. Эдийн засгийн асуудал

ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын эдийн засгийн асуудлыг илрүүлэхдээ бие хүн болж нийгэмшин амьдрахад шаардлагатай 14 суурь элементүүдийн сургалтын хөтөлбөрт тусгасан байдлыг шинжилж үзлээ.

Хүснэгт 3. Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан эдийн засгийн асуудал

Судлагдахуун	Товч дурдсан агуулга "1"	Хувь	Нэлээд дурдсан "2"	Хувь	Бүлгийн талаас тусгасан "3"	Хувь	Хөтөлбөр тус бүрт тусгагдсан элементийн нийт тоо	Хувь
Математик	7	2,6	0		0		7	0.8
Хими	7	2,6	14	5,2	7	2,6	28	3.4
Биологи	29	10,7	7	2,6	0		36	4.4
Монгол хэл	93	34,3	0		0		93	11.4
Физик	0		0		0		0	
Газарзүй	0		0		7	2,6	7	0.8
Англи хэл	14	5,2	0		0		14	1.7
Орос хэл	21	7,7	7	2,6	0		28	3.4
Нийгэм судлал	79	29,2	7	2,6	0		86	10.6
Түүх	21	7,7	71	26,2	0		92	16.4
Нийт	271	69,3	106	27,1	14	3,6	391	

Эдийн засгийн асуудлын элементүүд сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд товч дурдагдсан 69,3%, нилээд дурдсан 27,1%, бүлгийн талаас түлхүү тусгасан 3,6% байгаа нь ТХБ-ын эдийн засгийн агуулгыг судлагдахууны онцлогоос үл хамааран бүх сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд товч тусган оруулсан хувь өндөр харагдаж байна.



Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрүүдэд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын эдийн засгийн асуудлын элементүүд нийгэм соёл ба байгаль орчны асуудлуудын элементүүдээс харьцангуй бага тусгагдсан байна. Графикаас харахад бүлгийн талаас тусгасан болон нэлээд дурдсан судлагдахууны тоо товч дурдагдсан судлагдахууны тооноос бага байна. Товч дурдсан агуулгаас харахад ажилгүйдэл (Э1), ядуурал (Э2), шилжилт хөдөлгөөн (нийгмийн, газар зүйн) Э6, үнийн хөөрөгдөлт (Э7), үндэсний үйлдвэрлэл (Э10), эх дэлхийн нөөцийн хязгаарлагдмал боломж (Э11), зах зээлийн эдийн засаг (Э13) зэрэг элементүүдийг 3-4 судлагдахууны хөтөлбөрт тусгасан байна.

ТХБ-ын хандлага ба үнэт зүйлс заавал судлах сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд туссан байдал

Аливаа улс орны сургалтын хөтөлбөрт тухайн улсын иргэний үнэт зүйл юу вэ?, ямар хандлага төлөвшсөн иргэнийг бий болгох вэ? гэдэг асуудлыг тодорхойлон тусгадаг билээ. Монгол улсын хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан боловсролын хөгжлийн стратеги зорилго, зорилтод үндэслэн Монгол хүний үнэт зүйлд тулгуурласан хандлага төлөвшүүлэх агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлийг ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрт тусган хэрэгжүүлж буй үр дүнг хандлага ба үнэт зүйлс, чадвар ба чадамжийн үзүүлэлтээр илрүүлээ.

Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд хандлага ба үнэт зүйлийг нийгэм соёлын 14, байгаль орчны 6, эдийн засгийн 2 үзүүлэлтээр шинжилж үр дүнг нэгтгэлээ.

Хүснэгт 4. Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан хандлага ба үнэт зүйлс

Судлагдахуун	Товч дурдсан агуулга "1"	Хувь	Нэлээд дурдсан "2"	Хувь	Бүлгийн талаас тусгасан "3"	Хувь	Хөтөлбөр тус бүрт тусгагдсан элементийн нийт тоо	Хувь
Математик	42	24	21	16	0		63	13.3
Хими	8	5	4	3	17	7	29	5
Биологи	25	14	21	16	29	13	75	14.6
Монгол хэл	33	19	17	13	42	18	92	16.6
Физик	0		0		0		0	
Газарзүй	17	10	0		29	13	46	8.6
Англи хэл	0	0	0		33	14	33	4.6
Орос хэл	13	7	0		54	23	67	10
Нийгмийн ухаан	29	17	33	26	29	13	92	18.6
Түүх	8	5	33	26	0		42	10.3
Нийт	175	32.6	129	24.0	233	43.4	538	33.3

Хандлага ба үнэт зүйлийн элементүүд нийт сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд товч дурдсан 32,6%, нилээд дурдсан 24%, бүлгийн талаас түлхүү тусгасан 43,4% байна. Товч дурдсан сургалтын хөтөлбөрт математик, биологи, монгол хэл, газарзүйн хөтөлбөрүүд багтаж байхад нэлээд дурдсан хөтөлбөрүүдэд нийгмийн ухаан, түүхийн хөтөлбөрүүд, бүлгийн талаас түлхүү дурдсан хөтөлбөрт орос хэл, англи хэл, монгол хэл, биологи, газарзүйн хөтөлбөрүүд багтаж байна.



Хандлага үнэт зүйлийн ТХБ-ын үндсэн асуудлын элементүүд сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд бүлгийн талаас түлхүү тусгагдсан байна. Хандлага ба үнэт зүйлийн элементүүд сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд 30-90% туссан байна.

ТХБ-ын чадвар ба чадамж заавал судлах хичээлийн сургалтын цөм хөтөлбөрт туссан байдал.


Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд чадвар ба чадамж туссан байдлыг сэтгэн бодох ба асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, шинжлэн судлах, хувь хүний хөгжил, хандлага төлөвшилд чиглэсэн 5 багц агуулга- арга зүйн 42 шалгуур үзүүлэлтээр илрүүлж шинжилгээ хийлээ.

Хүснэгт 5. Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан чадвар ба чадамж

Судлагдахуун	Товч дурдсан агуулга "1"	Хувь	Нэлээд дурдсан "2"	Хувь	Бүлгийн талаас тусгасан "3"	Хувь	Хөтөлбөр тус бүрт тусгагдсан элементийн нийт тоо	Хувь
Математик	0		63	26	35	6.22	32	10.7
Хими	2	2	30	13	41	7.39	22	7.4
Биологи	0		0		98	17.5	18	5.9
Монгол хэл	33	33	2	1	63	11.3	45	15.1
Физик	7	7	63	26	26	4.67	37	12.5
Газарзүй	4	4	33	13	26	4.67	22	7.2
Англи хэл	33	33	24	10	28	5.06	48	16
Орос хэл	22	22	20	8	54	9.72	40	13.24
Нийгмийн ухаан	0		9	4	89	15.9	20	6.7
Түүх	0		0		98	17.5	18	5.8
Нийт	100	11.1	243	27.0	559	61.9	902	33.3

Чадвар ба чадамжийн агуулгын элементүүд нийт сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд товч дурдсан 11,1%, нилээд дурдсан 27%, бүлгийн талаас түлхүү тусгасан 61,9% байна.

График 5. Чадвар ба чадамжийн элементүүд



Чадвар ба чадамжийн агуулгын элементүүд нийт сургалтын цөм хөтөлбөрт бүлгийн талаас болон нэлээд дурдсан хөтөлбөрүүд их харагдаж байна. Чадвар ба чадамжийн элементүүд 8 –аас дээш сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд хангалттай тусгагдсан байна.

1.2. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал судлах цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүний сонголт туссан байдалд мэргэжлийн багш нарын өгсөн дүгнэлт, санал Сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээний хэсэгт ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг УБ хотын лаборатори 17 сургуулийн мэргэжлийн багш нарын саналыг авч нэгтгэлээ.

Хүснэгт 6. Сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжид ТХБ-ын үзэл санаа туссан талаарх мэргэжлийн багш нарын өгсөн санал

Судлагдахууны нэр	Зорилго, зорилт		Агуулга		Аргазүй		Үнэлгээний аргазүй	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Монгол хэл	+		+		+		+	
Математик	+		+		+		+	
Биологи	+		+		+		+	
Хими	+		+		+		+	
Физик	+		+		+		+	
Газарзүй	+		+		+		+	
Англи хэл	+		+		+		+	
Орос хэл	+		+		+		+	
Нийгмийн судлал	+		+		+		+	
Түүх	+		+		+		+	

УБ хотын лаборатори 17 сургуулийн мэргэжлийн багш нар сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжид ТХБ-ын орон нутгийн асуудал, мэдлэг, чадвар, үнэт зүйл хандлага, хэтийн төлөв зэрэг үндсэн агуулга туссан байдлыг шинжилсэн үр дүнгээс харвал “орон нутгийн асуудал”-ыг математик, биологи, нийгмийн ухаан, түүхийн сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусган оруулсан байна. Мэдлэгийн агуулгыг бүх сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн удирдамжид тусгаснаас математик, монгол хэлний багш нар суралцахуйн удирдамжид сайн туссан гэж хариулсан байхад чадварын агуулгыг бүх суралцахуйн удирдамжид маш сайн тусган оруулсан байна гэж үзсэн байна. Үнэт зүйл, хандлагын асуудлыг түүх, биологи, монгол хэлний суралцахуйн удирдамжид түлхүү тусгасан гэж үзсэн бол англи хэл, орос хэлний багш нар энэ талын агуулга тусгагдаагүй гэж хариулсан байна. ТХБ-ын “хэтийн төлөв”-ийн асуудлыг биологийн суралцахуйн удирдамжид түлхүү тусган оруулсан гэж үзсэн байна.

Мөн багш нар суралцахуйн удирдамжид ТХБ-ын цогц чадамж эзэмшүүлэх үйл ажиллагааг туссан байдлыг шинжилсэн. ТХБ-ын цогц чадамж суралцахуйн удирдамжид шууд ба дам байдлаар туссан талаар багш нарын санал, дүгнэлтээс харвал түүх, нийгмийн ухааны багш нар мэдэхийн тулд суралцах, хийхийн тулд суралцах, хамтарч амьдрахын тулд суралцах, оршин байхын тулд суралцах, өөрийгөө болон нийгмийг өөрчлөхийн тулд суралцах арга зүйг суралцахуйн удирдамжид шууд тусган оруулсан гэж хариулсан байхад орос хэл, англи хэлний багш нар энэ талын арга зүй суралцахуйн удирдамжид шууд тусаагүй гэж хариулсан байна. Биологи, химийн суралцахуйн удирдамжид өөрийгөө болон нийгмийг өөрчлөхийн тулд суралцах, хамтарч амьдрахын тулд суралцах, хийхийн тулд суралцах арга зүйг дам тусгасан гэж хариулсан хувь өндөр байхад, математик, физик, монгол хэлний суралцахуйн удирдамжид хийхийн тулд суралцах арга зүйг дам тусгасан байна гэж мэргэжлийн багш нар хариулсан байна. Харин англи хэл, орос хэл, нийгмийн ухааны суралцахуйн удирдамжид мэдэхийн тулд суралцах, хийхийн тулд суралцах, хамтарч амьдрахын тулд суралцах аргазүйг дам тусган оруулсан байна гэж үзсэн байна.

1.3. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн заавал сонгон судлах хичээлийн хэрэгжүүлэх хөтөлбөр, сургуулийн хөтөлбөр боловсруулахад тавигдах шаардлагад ТХБ-ын үзэл санааг тусгах боломжийг хэлэлцүүлсэн байдал
2016-2017 оны хичээлийн жилээс ЕБС-ийн ахлах ангид мөрдөх сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт сургууль орон нутгийн онцлогийг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх судлагдахууны чиглэлийг тусгасан. Төсөл хэрэгжих явцад бизнес судлал, дизайн технологи, мэдээллийн технологи, урлаг, спорт- эрүүл мэнд гэсэн 6 судлагдахууны сургуулийн хөтөлбөр боловсруулахад тавигдах шаардлага, сургуулийн хөтөлбөрт шинжилгээ хийх арга аргачлалыг таниулах сургалт зохион байгуулсан. Сургалтын явцад багш нар сургуулийн хөтөлбөр боловсруулахад орон нутгийн болон сургуулийн ТХБ-ын хүрээний тулгамдсан асуудлыг тодорхойлох дадлага ажил хийлээ. Дадлага ажлаар сургуулийн хөтөлбөрт тусгах тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон байдлаас харахад дараах нийтлэг асуудлуудыг дурдсан байна.

Хүснэгт 7. Орон нутаг ба сургуулийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд

Тулгамдсан асуудлууд	Байгаль орчин	Нийгэм, соёл	Эдийн засаг
Орон нутгийн	- Агаарын бохирдол, тоосжилт - Ус, хөрсний бохирдол - Хог хаягдал - Ногоон орчин,	- Хүн амын төвлөрөл - Зам, харилцаа, дэд бүтэц - Хүмүүсийн харилцаа, хандлага, зан төлөв, хүмүүжил - Сэтгэлгээний	- Хуримтлал, өрхийн санхүү - Амьжиргааны ялгаатай түвшин - Эдийн засгийн дэмжлэг, тогтвортой бодлого

	ногоон байгууламж	шинэчлэл МХХТ-ийн зөв зохистой ашиглалт	- Үйлдвэрлэлийг дэмжих
Сургуулийн	- Сургуулийн аюулгүй орчин - Орчны бохирдол, хогийн сав - Машины зогсоол - Хязгаарлагдмал байгаль орчин - Ногоон байгууламж	- Эцэг эхийн харилцаа, хандлага - Сургууль орчмын дэд бүтцийн асуудал - Сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал - Сургуулийн орчин дахь үйлчилгээний байгууллагуудын соёл - Сурталчилгаа, зөвлөгөө өгөх	- Тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хангалт - Бичиг хэргийн зардлын хэрэглээ - Сургалтын анги танхимын хүрэлцээ, засвар - Хамтын ажиллагаа - Хэмнэлт

Сургуулийн хөтөлбөрт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг мэргэжлийн багш нараар хэлэлцүүлж, сайжруулсан хувилбарыг боловсрууллаа.

Хүснэгт 8. Сургуулийн хөтөлбөрт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн бүтэц	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ		
		Хангалттай	Дунд	Хангалтгүй
Хөтөлбөрийн зорилго, зорилтын хувьд	Сургалтын хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын хууль эрх зүйн болон тухайн түвшний боловсролын зорилгод нийцсэн байх			
	Суралцахуйн зорилт нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, бодитой, цаг хугацаандаа хэрэгжихүйц (SMART) байх			
	Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх үндэсний болон дэлхий нийтийн чиг хандлагыг харгалзсан байх			
Хөтөлбөрийн агуулгын хувьд	Сурагчдын нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт нийцсэн байх			
	Сургалтын агуулга нь мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн, шинжлэх ухаанч байх			
	Академик болон прагматик агуулгын харьцааг зохистойгоор шийдвэрлэсэн байх			
	Агуулгын өргөсөл, гүнзгийрэл, залгамж холбоог хангасан, агуулгын интеграцийг оновчтойгоор тусгасан байх			
	Ахуй амьдрал, сурагчийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбосон байх			
	Сурагчдын ачааллыг зохистой хангасан, сургалтын төлөвлөгөөнд заасан цагт хэрэгжихүйц байх			
	Тогтвортой хөгжлийн болон хүний эрхийн боловсролын үзэл санааг тусгасан байх			
	Ахуйн ба шинжлэх ухааны үг хэллэг нэр томьёо ойлгомжтой байх			
	Ухагдахуун, ойлголт нь системтэй, логик дэс дараалалтай байх			
	Сурагчийн нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн ерөнхий зүй тогтол, онцлогийг харгалзсан байх			
	Тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн үндсэн зарчим, сургалтын технологийн			

Арга зүй, технологийн хувьд	шинэчлэлийг тодорхойлсон байх			
	Орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нийгэм, соёл, байгаль орчин, эдийн засгийн тулгамдсан асуудлыг сонгон судалж, шинжлэн судлах боломжийг олгосон байх			
	Сурагч мэдлэгээ өөрийн үйл ажиллагаагаар бүтээх орчин, нөхцөлийг бүрдүүлэн бие даан сурах арга барил эзэмшихэд чиглэсэн байх			
	Тухайн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай сурагчийн гүйцэтгэх үйл ажиллагааг тусгасан байх			
	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багшийн хөгжих боломжийг хангасан байх			
Хэрэглэг дэхүүний хувьд	Мэдээллийн технологийн давуу талыг ашиглах боломжтой, сурагч бүрт хүртээмжтэй, мэдлэг бүтээхэд дэмжлэг болохуйц сургалтын хэрэглэгдэхүүнийг зөвлөсөн байх			
	Арга зүйг дэмжсэн, тухайн насны хүүхэд хэрэглэх, шинжлэх ухааны судалгаа хийх тохиромжтой хэрэглэгдэхүүнийг сонгосон байх			
	Эрүүл ахуйд нийцсэн, хэрэглэгчид ашиглахад энгийн бүтэц, зохиомжтой, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй байх			
	Нэмэлт мэдээлэл олох эх сурвалжийг заасан байх			
Хөтөлбөрийн үнэлгээний хувьд	Үнэлгээний зорилт, шалгуурыг боловсруулсан байх			
	Үнэлгээний зорилт, шалгуур нь суралцахуйн зорилтыг илрүүлэхүйц боловсруулагдсан байх			
	Үнэлгээний хэмжээсжүүлэлт нь танин мэдэхүйн түвшний даалгаврын жин харьцаатай уялдсан байх			
	Үнэлгээний зорилт, шалгуурт нийцсэн явцын болон эцсийн үнэлгээний жишиг даалгаврын зарим жишээг боловсруулсан байх			
	Үнэлгээний даалгавар нь сурагч бүрийн ялгаатай байдлыг харгалзан үзэж, тэдний хөгжлийг дэмжихүйц байх			
	Явцын үнэлгээний даалгавар нь сурагчийн ахиц дэвшил, гүйцэтгэх үйлийн чанарыг үнэлэхэд хөтөлсөн байх			
	Эцсийн үнэлгээний даалгавар нь сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын үр дүнг үнэлэхүйц байх			

2. Ахлах ангийн хичээл, үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусгах судалгаат хичээл зохион байгуулсан байдал

- УБ хотын лаборатори 17 сургууль дээр мэргэжлийн багш нар баг болж тухайн судлагдахууны хичээлд ТХБ-ын үзэл санаа, агуулгыг тусган хэрэгжүүлэх жил, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулсан.
- Төлөвлөлтийн дагуу 17 судлагдахууны судалгаат хичээлийг зохион байгуулсан.
- Судалгаат хичээл хэлэлцүүлэг хийж, хичээл төлөвлөлтийг сайжруулсан.

Сургууль дээр зохион байгуулсан судалгаат хичээлүүдийг

- ТХБ-ын үзэл санаа, агуулгыг тусгасан хичээл
- ТХБ-ын агуулга, арга зүйг үнэлэх арга аргачлалыг оновчтой хэрэглэсэн хичээл
- Эдийн засгийн хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, мэдээллийн технологийн ололт, амжилтыг оновчтой ашиглах хэрэглэгдэхүүний сонголт хийсэн хичээл гэж ангилж үр дүнг нэгтгэлээ.

Ээлжит хичээл, үйл ажиллагаа зохион байгуулсан үр дүнг хичээл бүрээр харуулав.
 Хүснэгт 9. Хөтөлбөрийн үзэл брмтлал ба ТХБ-ын үзэл санааг тусган
 хэрэгжүүлсэн судалгаат хичээлүүд

Хичээл	Сэдэв	ТХБ-ын асуудал туссан эсэх				Тайлбар
		Агуул- гын хувьд	Арга- зүйн хувьд	Хэрэглэг дэхүүний хувьд	Үнэлгээний хувьд	
1. Монгол хэл бичиг	"Ирээдүйн өлсгөлөн"эсээн ний бүтэц, утгын задлал хийх		+	+	+	ТХБ-ын агуулга бүхий эхэд задлал хийсэн
2. Математик	Секторын талбай		+	+	+	Монгол орны усны нөөцийг дугуй диаграммаар илэрхийлэн тооцоолох Усаа хэмнэж хэрэглэх талаар ойлголттой болох
3. Биологи	Моногибрид эрлийзжүүлэг		+	+	+	Бусдыг сонсох, дахин ашиглагдах хэрэглэгдэхүүн сонгосон, багийн үйл ажиллагааг үнэлсэн хичээл болсон.
4. Хими	Метан гарган авах		+	+	+	Хийн түлшний ач холбогдол хор хөнөөлийг таниулах агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг тусгасан.
5. Физик	Фото-резистор, түүнийг хэрэглэх		+	+	+	Агуулгын хувьд: Эрчим хүч, түүнийг хэрхэн зөв, хэмнэлттэй хэрэглэх Аргазүйн хувьд:Багаар ажиллуулсан хамтын шийдвэр гаргах, бусдын саналд хүндэтгэлтэй хандах, туршилт судалгаа хийх Хэрэглэгдэхүүний хувьд:эдийн засгийн хуьд хэмнэлттэй,дахин ашиглах боломжтой хэрэглэгдэхүүн ашигласан.
6. Газарзүй	Усны хэрэглээ	+	+	+	+	Усны зохистой хэрэглээг ухамсарлан өдөр тутмын үйл ажиллагаагаар дамжуулж усыг хэмнэх, хэвшүүлэх агуулга арга зүйн интеграцийг тусгасан.
7. Англи хэл	Сайн дурын ажилтан				+	Дахин ашиглах хэрэглэгдэхүүн сонгосон (цагаан самбар)
8. Орос хэл	Миний өрөө				+	

9. Нийгэм судлал	Тогтвортой хөгжилд бидний оролцоо	+	+		+	Амьдралын чанараа дээшлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүрээнд судлан тодорхойлох агуулга болон тэдгээрийн шалтгаан, үр дагавар, шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэх арга зүйг тусгасан.
10. Түүх	Археологийн дурсгалаар түүхийг танин мэдэх	+	+	+	+	Археологийн дурсгалуудыг танин мэдэх ба тэдгээрийг тогтвортой хөгжлийн үзэл санаатай холбон харьцуулсан шинжилгээ хийж үндэслэлтэйгээр тайлбарлах
11. Спорт эрүүл мэнд	Сагсан бөмбөгийн залалт		+	+		Багийн үйл ажиллагааг дэмжсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан хэрэглэгдэхүүн сонгосон.
12. Мэдээллийн технологи	Агаарын бохирдол сэдвээр мультимедиа бүтээл хийх	+	+	+	+	Агуулга, арга зүйн интеграци хийсэн, мэдээллийн технологийн ололт, амжилтыг оновчтой ашигласан.
13. Дизайн технологи	Sketch up программ ашиглан байшингийн макет загвар гаргах			+	+	Байгальд ээлтэй хэрэглэгдэхүүнийг сонгоход анхаарсан.
14. Зураг зүй	Механик ба цахилгаан хөдөлгүүр			+	+	Эрүүл ахуйн шаардлага хангасан хэрэглэгдэхүүний сонголт хийсэн.
15. Урлаг	Хог хаягдал	+	+	+	+	Агуулга, арга зүйн интеграци хийсэн, урийн сангаар дамжуулж ТХБ-ын үзэл санааг ойлгуулах, дахин хэрэглэх, эдийн засгийн хэмнэлттэй хэрэглэгдэхүүн сонгосон.
16. Бизнес судлал	Хуримтлал ба зардал	+	+	+	+	<ul style="list-style-type: none"> • Хувь хүний зардал, түүний төрөл ялгааг ангилах, тооцоолох • Бодит хэрэгцээ ба хүсэж буй зүйлс хоёрын хоорондын ялгааг ухаарах • Зайлшгүй хэрэгцээтэй зүйлсээ илрүүлж, зардлын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх алхам хийх • Зардлыг хэмнэх аргаас суралцах
17. АЧСҮА	Цуглуулсан мэдээлэлд дүн	+	+	+	+	Цуглуулсан мэдээлэлд үндэслэн тулгамдсан асуудлаа хэлэлцэж,

	шинжилгээ хийх					хамтын шийдвэр гаргах <ul style="list-style-type: none"> • Бохирдлын талаар цуглуулж ирсэн мэдээллээ бусдад танилцуулах • Хэлэлцэх • Дүгнэлт гаргах арга зүйг тусгасан.
--	-------------------	--	--	--	--	--

ДҮГНЭЛТ

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, хэрэгжүүлэх хөтөлбөр, хичээл, үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санаа туссан талаар шинжилгээ хийснээр дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрүүдийн төсөлд ТХБ-ын үзэл санааг тусгасан байгаа бөгөөд судлагдахууны онцлогоос хамааран харилцан адилгүй байна.

Тухайлбал:

1. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжүүлэх нийгэм, хүмүүнлэгийн ухаан (түүх, нийгмийн ухаан, орос хэл, монгол хэл, англи хэл)- ы сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын нийгэм соёлын асуудал түлхүү тусгагдсан байна.
2. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжүүлэх заавал судлах сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын байгаль орчны асуудал жигд тусгагдсан байна. Байгаль орчны асуудлыг бүлгийн талаас илүү тусгасан хичээлүүдэд газар зүй, биологи, хими болон нийгэм судлалын хичээлүүд байгаагаас харахад судлагдахууны онцлогоос хамаараад байгалийн ухааны хичээлүүдэд бүлгийн талаас илүү түлхүү тусгасан боловч нийгмийн ухаан, хүмүүнлэгийн хичээлүүдэд товч дурдагдсан байгаа нь аль ч сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд байгаль орчны асуудлын элементүүд жигд тусгагдсан байна гэдгийг харуулж байна.
3. Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангид хэрэгжүүлэх заавал судлах сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ-ын танин мэдэхүйн агуулгын эдийн засгийн асуудлын элементүүдийг товч дурдсан байна.
4. Хандлага ба үнэт зүйлийн элементүүд шинжилгээ хийсэн 10 сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд товч дурдсан 32,6%, нилээд дурдсан 24%, бүлгийн талаас түлхүү тусгасан 43,4% байна.
5. Чадвар ба үнэт зүйлийн элементүүдийг бүх сургалтын хөтөлбөрт сайн тусган оруулсан байгаа нь суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт сурах арга барил эзэмшүүлэх арга зүйн шинэчлэл хийсэнтэй холбоотой байж болох юм.
6. 10 дугаар ангид хэрэгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрийн төслийг 17 судлагдахууны 92 багш уншиж танилцсан бөгөөд багш нар сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилтын уялдаатай байдал, агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрэл, арга зүй ба үнэлгээний зорилт, шалгуурын талаар ойлголттой болсон.
7. Мэргэжлийн багш нар ахлах ангийн 10 дугаар ангийн сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн төслийг уншиж судлаад зорилго зорилт, агуулга, арга зүй, үнэлгээний хэсэгт ТХБ-ын үзэл санаа туссан байна гэж дүгнэлт хийсэн хэдий боловч сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжид багш нар шинжилгээ хийсэн үр дүнгээс харахад ТХ-ын үзэл баримтлал, ТХБ-ын агуулга, арга зүйн талаар зөрүүтэй ойлголт байгаагаас харилцан адилгүй хариулт өгсөн байдал ажиглагдаж байна.
8. УБ хотын 17 лаборатори сургуулийн хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлэх, боловсруулах, турших, үр дүнд шинжилгээ хийж хэрэгжүүлэх арга зүйд суралцан гарааны ажлуудыг төлөвлөж эхэлсэн байна. Багш нар сургуулийн хөтөлбөр боловсруулахад орон нутаг, сургуулийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлон, орон нутгийн хөгжлийг дэмжсэн, сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн, сурагчийн хэрэгцээ, сонголтод үндэслэсэн сургалтын хөтөлбөр боловсуулж хэрэгжүүлэх арга зүйг эзэмшсэн.

9. Ээлжит хичээлд ТХБ-ын үзэл санааг тусгах талаар 17 хичээл, үйл ажиллагааны жишээ баримтан дээр тулгуурлан хэлэлцүүлэг өрнүүлэв. Уг хэлэлцүүлгийн үр дүнд өмнө заагдсан ээлжит хичээлийн төлөвлөлт, агуулга, арга зүй, үнэлгээг сайжруулж, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бэлтгэл хангаж видео хичээл бэлтэв.

САНАЛ

1. Сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг шинжилсэн шалгуур үзүүлэлтийг цаашид сайжруулан боловсруулж, сургалтын хөтөлбөр, сурах бичигт шинжилгээ хийх мэргэжлийн шинжээчдийг бэлтгэхэд анхаарах
2. ТХБ-ын үзэл санааг хичээл, үйл ажиллагаанд тусгах судалгаат хичээлийг үндэсний хэмжээнд зохион байгуулах
3. ТХ-ийн үзэл баримтлал, ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй, үнэлгээ ба хэрэглэгдэхүүн сонголтын талаар багш нарын ойлголт харилцан адилгүй байгаа нь хичээл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба хэлэлцүүлгийн явцад ажиглагдсан. Иймээс багш бэлтгэх, давтан сургах сургалтын агуулгад ТХ-ийн үзэл баримтлал, ТХБ-ын агуулга, арга зүйн шинэчлэлийн талаар тусган оруулахад анхаарах хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ

1. БСШУЯ. “Олон түвшинт суурь судалгаа”, 2016
2. БСШУЯ. Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага. 2016
3. Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал.2013
4. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн төсөл.2016
5. Монгол улсын ТХБ/ТХ/НХ-ийн өнөөгийн бодлого, эрхзүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа, Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл, 2015
6. Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжигч Олон улсын Эко-сургууль хөтөлбөрийн Монгол дахь оператор байгууллага “Байгаль орчны мэдээлэл сургалтын бүтээл”.
7. A Cross-Curricular Framework for Global Development Education in the Context of Education for Sustainable Development, 2009
8. Embedding Sustainable Development in the Curriculum
http://www.eauc.org.uk/sorted/files/esd-embedding_1.pdf
9. 제목독일의제목: ‘지속가능한발전을위한교육(BLK 21) 프로그램’ 조사
연구를통한전공포괄적학교환경교육프로그램및수업지도안개발
www.kbedu.or.kr/bbs/data/kbedu_or_kr/ins_bbs2/BLK21.pdf
10. Green-Schools Towards a sustainable lifestyle, Water, хуудас 3
11. UNESCO Education Sector. United Nations Decade of Education for Sustainable Development (2005-2014) Education for Sustainable Development Lens: A Policy and Practice Review Tool
12. Embedding sustainable development in the curriculum
13. Quality Criteria for ESD-Schools
<http://www.ensi.org/global/downloads/Publications/208/QC-GB.pdf>

БДБ-ЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТХБ-ЫН ҮЗЭЛ САНАА ТУССАН БАЙДЛЫГ ИЛРҮҮЛЭХ ШАЛГУУР

Танилцуулга

Боловсролын болон ТХ-ийн индикаторууд уялдах байдлаар сургалтын баримт бичигт шинжилгээ хийх нь боловсролын бодлого боловсруулах, чанарыг баталгаажуулах, хөтөлбөр сурах бичиг боловсруулж туршиж хэрэгжүүлэх, үнэлж сайжруулах менежментийн тогтолцоог бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Судлагдсан байдал

Боловсролын баримт бичигт ТХБ-ын үзэл санааг тусгаж ирсэн онол, арга зүйн шийдлийг илрүүлэх чиглэлээр Монгол улсад хийгдсэн дараах судалгаа, арга зүйн баримт бичгүүдэд үндэслэсэн болно. Үүнд:

- 2014 онд БСШУЯ, МУБИС-аас хийсэн “Олон түвшинт суурь судалгаа”
- БСШУ-ны сайдын 2016 оны 11-р сарын 13-ны А/458-р тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага”

Сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа туссан байдлыг илрүүлэх шалгуур

А. Танин мэдэхүйн агуулга

Сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд ТХБ үндсэн агуулга буюу мэдлэг ойлголт, чадвар, асуудал, хэтийн төлөв, үнэт зүйлийн талаар тусгагдсан байдлыг 0 – 3 гэсэн тоогоор тэмдэглэнэ үү.

Элемент	Байдал	Код	Дурдаагүй бол “0”	Товч дурдсан бол “1”	Нэлээд дурдсан бол “2”	Бүлгийн талаас илүүд “3”
Нийгэм-соёлын асуудал:						
Нийгмийн хөгжил		H1				
Нийгмийн зөрчил, зөвшилцөл		H2				
Ялгаварлан гадуурхал		H3				
Хүний эрх		H4				
Дэлхийн тэгш байдал ба шударга ёс		H5				
Ирээдүйн үеийн эрх		H6				
Авлига, хээл хахуул		H7				
Хүчирхийлэл		H8				
Үйлчилгээний чанар, хүртээмж		H9				
Энх тайван ба аюулгүй байдал		H10				
Жендер, жендерийн тэгш байдал		H11				
Эрүүл мэнд		H12				
Харилцаа		H13				
Хэл соёл		H14				
Шашин шүтлэг		H15				
Соёлын ялгаатай байдал ба соёл хоорондын ойлголцол		H16				
Сайн засаглал		H17				
Аюул осол, эрсдлээс сэргийлэх		H18				

(ХДХВ/ДОХ, мансууруулах бодис, хүний наймаа гэх мэт)					
Хэвлэлийн эрх чөлөө	H19				
Даяаршил, дангааршил	H20				
Соёлын өв, түүний хамгаалал	H21				
Соёлын шинэчлэл	H22				
Соёлын шүүмжлэл	H23				
Уламжлалт мэдлэг	H24				
Шашин ба итгэл үнэмшлийн тогтолцоо	H25				
Соёлын эрх чөлөө	H26				
Хот, хөдөөгийн ялгаа	H27				
Суурин ба нүүдлийн соёлын зөрчил	H28				
Үндэстэн ястны зан заншил	H29				
Байгаль орчны асуудал					
Цөлжилт, ой устгал	Б1				
Байгалийн нөөц баялаг түүний хамгаалал	Б2				
Аж үйлдвэр, уул уурхай	Б3				
Байгалийн гамшиг	Б4				
Ус	Б5				
Агаар	Б6				
Хөрс	Б7				
Эрчим хүч	Б8				
Хөдөө аж ахуй, бэлчээр ашиглалт	Б9				
Экосистемийн доройтол	Б10				
Биологийн төрөл зүйлийн олон янз байдал (ургамал, амьтан гэх мэт)	Б11				
Уур амьсгалын өөрчлөлт	Б12				
Хөдөөгийн хөгжил	Б13				
Хотжилт	Б14				
Хүн, амьтан, ургамал	Б15				
Бохирдол	Б16				
Хог хаягдал	Б17				
Нөхөн сэргээлт	Б18				
Уламжлалт мэдлэг	Б19				
Экологийн мөр	Б20				
Эдийн засгийн асуудал					
Ажилгүйдэл	Э1				
Ядуурал	Э2				
Зохистой хэрэглээ	Э3				
Эдийн засгийн тэгш бус байдал	Э4				
Шилжилт хөдөлгөөн (нийгмийн, газар зүйн)	Э6				
Үнийн хөөрөгдөлт	Э7				
Хэр хэмжээнээс хэтэрсэн зээл	Э8				
Импорт экспортын өсөлт, бууралт	Э9				

Үндэсний үйлдвэрлэл	Э10				
Эх дэлхийн нөөцийн хязгаарлагдмал боломж	Э11				
Компаний нийгмийн хариуцлага	Э12				
Зах зээлийн эдийн засаг	Э13				
Үйлдвэрлэл ба хэрэглээ	Э14				

Б. Хандлага, үнэт зүйлс.

ТХБ-ын хандлага, үнэт зүйлсийн элементүүд сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан байдлыг 0 – 3 гэсэн тоогоор тэмдэглэнэ үү.

Хандлага, үнэт зүйлс	Код	Дурдаагүй бол “0”	Товч дурдсан бол “1”	Нилээд дурдсан бол “2”	Бүлгийн талаас илүүд “3”
Нийгэм –соёлын асуудал					
Нийгмийн оролцоо	НХҮ1				
Ёс зүйтэй байх	НХҮ2				
Шударга ёс	НХҮ3				
Үл ялгаварлал	НХҮ4				
Эрх үүрэг	НХҮ5				
Мэдрэмж	НХҮ6				
Сонголт	НХҮ7				
Итгэл үнэмшил	НХҮ8				
Яс үндэс	НХҮ9				
Ашиг сонирхол	НХҮ10				
Энэрэнгүй үзэл	НХҮ11				
Хүнлэг ёс	НХҮ12				
Бие даасан байдал	НХҮ13				
Өөрийн болон бусдын үнэт зүйлсийг ойлгох	НХҮ14				
Байгаль орчны асуудал					
Байгаль орчноо хамгаалах	БХҮ1				
Байгаль орчинд ээлтэй хандах	БХҮ2				
Нөхөн сэргээгдэх байдал	БХҮ3				
Урьдчилан сэргийлэх	БХҮ4				
Бусдад үйлчлэх байдал	БХҮ5				
Байгаль орчноо энэ хэвээр нь хойч үедээ хүлээлгэн өгөх	БХҮ6				
Эдийн засгийн асуудал					
Ёс суртахуунтай байх	ЭХҮ1				
Ашгийг тэгш хуваарилах, хүртээх	ЭХҮ2				

В. Чадвар ба чадамж.

ТХБ-ын чадвар ба чадамжийн элементүүд сургалтын цөм хөтөлбөрийн төсөлд тусгагдсан байдлыг 0 – 3 гэсэн тоогоор тэмдэглэнэ үү.

Чадвар	Код	Дурдаагүй бол “0”	Товч дурдсан бол “1”	Нэлээд дурдсан бол “2”	Бүлгийн талаас илүүд “3”
Бүтээлчээр эргэцүүлэх, сэтгэх	Ч1				

Асуулт, асуудал, боломжит хувилбаруудын тухай бүтээлчээр сэтгэх	Ч2				
Үнэ цэнийг тодорхойлох болон тодруулах	Ч3				
Асуудалд тогтолцооны шинжилгээний үүднээс хандах	Ч4				
Шийдвэр гаргах, тодорхой бус нөхцөлд шийдвэр гаргах	Ч5				
Асуудлыг ойлгох, эргэцүүлэх, шийдвэрлэх	Ч6				
Хэлцэл, зөвшилцөл бий болгох	Ч7				
Оролцогч талууд, тэдний сонирхол,эрх ашгийг тодорхойлох	Ч8				
Зөрчлийг ухаалгаар шийдвэрлэх	Ч9				
Хямрал ба эрсдэлийг зохицуулах	Ч10				
Ардчилсан шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох	Ч11				
Хэлцэлболон зөвшилцөлбий болгох	Ч12				
Асуудал зөрчлийг эв эээр шийдвэрлэх	Ч13				
Мэдээлэл цуглуулах, (ангилах, харьцуулах, тодорхойлох, хэмжих, тооцоолох гэх мэт)	Ч14				
Логик болон бүтээлч учир шалтгааны дагуу мэдээллийг цуглуулах мэдээлэлд үнэлгээ хийх, задлан шинжлэх	Ч15				
Тухайн тохиолдолд өөрийн туршлага санаа бодолдоо дүн шинжилгээ хийж бусад эх үүсвэрүүдтэй харьцуулах	Ч16				
Нарийн төвөгтэй байдлыг ойлгох/бүхэл цогц байдлаарсэтгэх	Ч17				
Тогтвортой хөгжихүйн зарчим ба практикт холбоотой төрөл бүрийн нөлөөг үнэлэх	Ч18				
Судалгаанд үндэслэж үнэлэлт, дүгнэлт, шийдвэр гаргах, санал дэвшүүлэх	Ч19				
Таамаглах, төсөөлөх	Ч20				
Ангилах	Ч21				
График, дүрс тэмдгийг ойлгох, тэдгээртэй харилцах	Ч22				
Ажиглалтад үндэслэж дүгнэлт гаргах	Ч23				
Бүтээлчээр сэтгэх, өөрийгөө илэрхийлэх	Ч24				

Хамтран ажиллах	Ч25				
Бусдаас суралцах	Ч26				
Өөрийгөө шинжин таних, үнэлэх, удирдах Бодит мэдээлэл, хувийн үзэл бодлыг ялгах	Ч27				
Ажиллаж амьдрах явцдаа суралцан хөгжих	Ч28				
Багаар ажиллах	Ч29				
Хариуцах, хариуцлага хүлээх	Ч30				
Дасан зохицох	Ч31				
Өөрчлөлтөд бэлэн тооцоотой байх	Ч32				
Хүлээцтэй байх	Ч33				
Манлайлан зохион байгуулах	Ч34				
Ирээдүйг төсөөлөх	Ч35				
Аливааг үйлдэхдээ бусдыг хүндлэх	Ч36				
Өөрийгөө бусадтай харьцуулж үнэ цэнийг ойлгох	Ч37				
Хичээлүүдийн хоорондын уялдаа холбоог ойлгох	Ч38				
Эх дэлхийн хязгаарлагдмал нөөцөд зохицон ажиллах	Ч39				
Технологийг зүй зохистой ашиглах	Ч40				
Тогтворшилтой хөгжлийн боловсролын үйл ажиллагаанд болон суралцахууд шинэ технологийг хэрэглэх	Ч41				
Технологийн чадвартай хэрэглээ ба нийгэм, эдийн засгийн орчин холбоо хамаарлыг тогтоох	Ч42				

Сургалтын цөм хөтөлбөрийн төсөл, суралцахуйн удирдамжид ТХБ-ын үзэл санаа туссан байгаа талаар багшийн өгөх саналын хуудас

Хичээл судлагдахууны нэр.....

Асуулт		Хариулт		
Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг	ТХБ-ын үзэл санаа туссан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тэмдэглэнэ үү	Зорилго, зорилт	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
		Агуулга	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
		Арга зүй	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
		Үнэлгээ	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тийм бол тодорхой жишээг бичнэ үү			
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж	ТХБ-ын үзэл санаа хөтөлбөрийн зөвлөмжид туссан бүрэлдэхүүн хэсгүүдийг тэмдэглэнэ үү	Суралцахуйн зорилт	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
		Суралцахуйн үйл ажиллагаа	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
		Хэрэглэгдэхүүн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тийм бол тодорхой жишээг бичнэ үү			

**Бүрэн дунд боловсролын.....судлагдахууны сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжид
ТХБ-ын агуулга туссан байгааг шинжлэх хуудас**

Бүлэг сэдэв	Суралцахуйн зорилтын тоо	Суралцахуйн зорилтын тоо				
		Орон нутгийн асуудал	Мэдлэг	Чадвар	Үнэт зүйл, хандлага	Хэтийн төлөв
НИЙТ						

